|-------------|----------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 3,928,700.00          | 3,696,034.20          | 232,665.80           | 94.0         |
| 210404      | Ном, хэвлэл                                                          | 517,500.00            | 516,000.00            | 1,500.00             | 100.0        |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,589,100.00          | 1,589,080.00          | 20.00                | 100.0        |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                              | <b>1,058,700.00</b>   | <b>1,058,700.00</b>   | -                    | <b>100.0</b> |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                          | 1,058,700.00          | 1,058,700.00          | -                    | 100.0        |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>440,000.00</b>     | <b>440,000.00</b>     | -                    | <b>100.0</b> |
| 210604      | Урсгал засвар                                                        | 440,000.00            | 440,000.00            | -                    | 100.0        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>64,938,900.00</b>  | <b>64,073,786.00</b>  | <b>865,114.00</b>    | <b>99.0</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 59,122,000.00         | 58,717,484.00         | 404,516.00           | 99.0         |
| 210802      | Аудит, баталгаажуулалт                                               | 2,000,000.00          | 2,000,000.00          | -                    | 100.0        |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                                                  | 2,163,900.00          | 1,891,890.00          | 272,010.00           | 87.0         |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 730,000.00            | 641,412.00            | 88,588.00            | 88.0         |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                        | 243,000.00            | 143,000.00            | 100,000.00           | 59.0         |
| 210807      | Газрын төлбөр                                                        | 680,000.00            | 680,000.00            | -                    | 100.0        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>2,512,000.00</b>   | <b>2,512,000.00</b>   | -                    | <b>100.0</b> |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,512,000.00          | 2,512,000.00          | -                    | 100.0        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | <b>328,000.00</b>     | <b>300,000.00</b>     | <b>28,000.00</b>     | <b>91.0</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | <b>328,000.00</b>     | <b>300,000.00</b>     | <b>28,000.00</b>     | <b>91.0</b>  |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 328,000.00            | 300,000.00            | 28,000.00            | 91.0         |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>695,788,600.00</b> | <b>658,089,741.13</b> | <b>37,698,858.87</b> | <b>95.0</b>  |

|             |                                    |                       |                       |                      |              |
|-------------|------------------------------------|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС<br/>САНХҮҮЖИХ</b> | <b>695,788,600.00</b> | <b>658,089,741.13</b> | <b>37,698,858.87</b> | <b>95.0</b>  |
| 131001      | Улсын төсвөөс<br>санхүүжих         | 695,788,600.00        | 658,089,741.13        | 37,698,858.87        | 95.0         |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН<br/>ТОО</b>        | <b>1</b>              | <b>1</b>              | <b>-</b>             | <b>100.0</b> |
| 610001      | Төсвийн байгууллага                | 1                     | 1                     | -                    | 100.0        |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>             | <b>35</b>             | <b>35</b>             | <b>-</b>             | <b>100.0</b> |
| 620001      | Удирдах ажилтан                    | 1                     | 1                     | -                    | 100.0        |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                  | 27                    | 27                    | -                    | 100.0        |
| 620003      | Үйлчлэх ажилтан                    | 7                     | 7                     | -                    | 100.0        |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт                                                                                                   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл             |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                                                   |            | -                     |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                       |            | -                     |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                                     |            | <b>581,203,143.80</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                                                   |            | <b>7,810,000.00</b>   |
| 210101      | Үндсэн цалин                                                                                               |            | 5,010,000.00          |
| 210104      | Урамшуулал                                                                                                 |            | 2,800,000.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                                                      |            | -                     |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                                                         |            | -                     |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                    |            | <b>38,311,340.00</b>  |
| 210401      | Бичиг хэрэг                                                                                                |            | 600,000.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                                                           |            | 11,906,000.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                                                         |            | 256,080.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                                                |            | 25,549,260.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                                                   |            | <b>146,664,620.00</b> |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                                                                    |            | 140,304,920.00        |
| 210602      | Тавилга                                                                                                    |            | 3,000,000.00          |
| 210604      | Урсгал засвар                                                                                              |            | 3,359,700.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                                                              |            | <b>8,934,000.00</b>   |
| 210702      | Дотоод албан томилолт                                                                                      |            | 8,934,000.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                                            |            | <b>297,216,450.00</b> |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       |            | 297,216,450.00        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                    |            | <b>82,266,733.80</b>  |
| 213305      | Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлэг                                                                |            | 82,266,733.80         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                      |            | <b>581,203,143.80</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                         |            | <b>581,203,143.80</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж                                        |            | 74,612,343.80         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |            | 506,590,800.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               |            | -                     |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                                                            |            |                       |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                           |            |                       |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                          |            |                       |



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд засгийн газрын 43-р тогтоолын дагуу ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн аудитор М.Мөнхтөгс, аудиторов туслах Ц.Бат-Өлзий нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ч.Энхчимэг, чанарын хяналтын менежер Д.Мядагмаа нар хэрэгжүүлсэн.

Соёлын өвийн үндэсний төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 01/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Соёлын өвийн үндэсний төвийн эрхэм зорилго нь Соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үндэсний сүлжээг бий болгон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн соёл, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллага байхад оршино.

Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт, судалгаа хийх, сурталчлах, түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах, соёлын өвийг авран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Соёлын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2021 оны 4 дүгээр улиралд Соёлын өвийн үндэсний төвийн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 19 нэр төрлийн мэдээллийг 149 талбарт мэдээлэхээс 3 талбарт хугацаа хоцроосонд зөвлөмж өгч, шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 98.0 хувьтай байна гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,017,093.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,170.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 242,967.1 мянган төгрөгөөр буюу 45 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт         |
|-------------------------------------------------------|-------------------|--------------------|------------------|
| Б                                                     | 1                 | 2                  | 3=2-1            |
| Авлага                                                | 18,434.0          | 82,185.9           | 63,751.9         |
| Урьдчилгаа                                            | 36,490.0          | 70,088.0           | 33,598.0         |
| Бараа материал                                        | 139,103.3         | 158,031.3          | 18,928.0         |
| Үндсэн хөрөнгө                                        | 346,286.4         | 472,841.2          | 126,554.8        |
| <b>Нийт хөрөнгө</b>                                   | <b>540,313.7</b>  | <b>783,146.4</b>   | <b>242,832.7</b> |
| Өр төлбөр                                             | 90.6              | 0.0                | (90.6)           |
| Засгийн газрын хувь оролцоо                           | 540,223.1         | 783,146.4          | 242,923.3        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө<br/>өмчийн дүн</b> | <b>540,313.7</b>  | <b>783,146.4</b>   | <b>242,832.7</b> |

Авлага дансны үлдэгдэл 82,185.9 мянган төгрөг болж, 63,751.9 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд үүссэн Өнөр арслан ХХК-аас 5,826.0 мянга, нэр данс зөрүү 1,916.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, Юнескогоос 884.7 мянга, дээд шатны байгууллагаас 70,610.0 мянган төгрөгийн авлага нэмж үүссэнээс шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 70,088.3 мянган төгрөг болж, 33,598.0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлээс 29,110.0 мянган төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч, тайлант онд Булган аймгийн Могод, Орхон суманд хэв авч, хуулбар хийх, соёлын биет өвийг сэргээн засварлах ажилд 62,708.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 158,031.3 мянган төгрөг болж, 18,928.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 80,741.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 61,813.1 мянган төгрөгийн бараа материал урсгал үйл ажиллагаанд зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 472,841.2 мянган төгрөг болж, 126,554.8 мянган төгрөгөөр өссөн нь 85,835.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГазрын 2021 оны 05 сарын 18-ны А-1/789 тоот албан бичгээр 11,750.0 мянга, 2021 оны 10 дугаар сарын 19-ны 434 тогтоолоор 166,996.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ТӨБЗГазарын А-1/1977 тоот албан бичгээр 10,860.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл балансаас балансад, Соёлын яамнаас 1,654.4 мянган төгрөгийн компьютер үнэ төлбөргүй шилжүүлэн авч данс бүртгэлд тусган, тайлант онд 90,224.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 сарын 14-ны 675 тоот албан бичгээр 31,015.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 90.6 мянган төгрөгөөр буурсан нь Монгол шуудан ХК-д төлөх өглөгийг төлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 783,280.8 мянган төгрөг болж 243,057.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Соёлын өвийн үндэсний төв санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 536,620.7 мянган төгрөгөөр буюу 60 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан 130,961.2 мянган төгрөгийн хөрөнгө, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид нэмэлт санхүүжилтээр олгосон 500,764.8 мянган төгрөгийн санхүүжилт байна. Энэ нь археологийн авран хамгаалах судалгааны ажлын санхүүжилт, археологийн олдвор хадгалах зориулалтын сан хөмрөгийн өрөө байгуулах, амжилтын эзэд контент, Соёлын өвийн үнэлгээ, асуудал, шийдэл боломж зөвлөлдөх уулзалт, Сүм хийдийн үнэт зүйл, хэрэглээ, хамгаалал, зохицол хөгжил хэлэлцүүлэг, Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх, хуулбар хийх, Дэл уулын хадны зураг тусгай үзэсгэлэн зохион байгуулах, СББӨ-ийн УНБМСангийн орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, Соёлын баримтат өвийг сэргээн засварлах техник, тоног төхөөрөмж бэлтгэх зэрэг зардлын санхүүжилт байна.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 131,284.6 мянган төгрөгөөр буюу 13 хувиар хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл 49,327.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 247,299.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 1,451,527.7 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,446,827.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 4700.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас урсгал зардлыг 751,367.1 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг 4,372.0 мянга буюу нийт төсвийг 755,739.1 мянган төгрөгөөр бууруулан, 695,788.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 68-р тогтоолоор баталсан “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн арга хэмжээ, 2019 оны 69-р тогтоолоор баталсан “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хангаж хэрэгжүүлэхээр түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал, ажиллагсдын орон тоо, шинээр баригдсан өөрийн байранд нүүн орж, үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан төлөвлөсөн зардлуудыг бууруулан баталсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 43 арга хэмжээг санхүүжүүлэхээр 695,788.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 695,788.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 695,788.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 658,089.7 мянган төгрөгийг зарцуулж 37,698.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 658,089.7 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 30,735.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардлыг 5,831.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 239.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 865.1, тэтгэмжийн зардлыг 28.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

|          | Хөтөлбөр, арга хэмжээний нэр                                                                                           | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|----------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------|----------|---------|
| 1        | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилт                                                                   | 19,613.2   | 18,671.8  | 941.4    | 95.2    |
| 2        | Хуулиар тусгайлан олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд                                             | 47,272.9   | 47,110.1  | 162.8    | 99.6    |
| 3        | Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд                                                       | 5,966.0    | 5,966.0   | 0.0      | 100     |
| 4        | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ                                                  | 36,958.2   | 36,958.2  | 0.0      | 100     |
| 5        | Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах | 3,838.5    | 3,838.5   | 0.0      | 100     |
| 6        | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах                                                        | 582,139.8  | 545,545.1 | 36,594.7 | 93.7    |
| Нийт дүн |                                                                                                                        | 695,788.6  | 658,089.7 | 37,698.9 | 95.0    |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 74,612.3 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 506,590.8 мянга, нийт 581,203.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 7,810.0 мянга, хангамж бараа материалын зардалд 38,311.3 мянга, эд хогшил худалдан авахад 146,664.6 мянга, томилолтын зардалд 8,934.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажилд 297,216.5 мянга нийт 498,936.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 82,266.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Соёлын өвийн үндэсний төв нь таван алба, хэлтсээс бүрддэг. Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 хөтөлбөр, 43 арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.0 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд урсгал зардалд 658,089.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Амжилтын эзэд контентын зардал 180,000.0 мянган төгрөг, Археологийн олдвор нүүлгэх зардал 6,600.0 мянган төгрөг, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт " Өлзийт дэнж" дурсгалыг хамгаалах, судалгаа хийх зардал 20,000.0 мянган төгрөг, Соёлын биет бус өвийн тухай дүрс бичлэгээр баримтжуулсан 30-н цуврал баримтат кино бүтээхэд 8,538.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг төлөвлөөгүй дээд шатны төсөв захирагч хянахдаа ч нэмж баталж өгдөггүй байна.

Соёлын өвийн үндэсний төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 19 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Соёлын өвийн үндэсний төв нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 146 мэдээллийг байршуулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдэл, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байгаа нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг хэрэгжүүлж 9,156.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 375.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрсэнд залруулах зөвлөмж өгсөн, жилийн эцсийн аудитаар дахин хянахад 3 алдааг залруулж, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 22,207.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 21,261.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 946.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |          | Биелэлт |          | Зөрүү |     |      |
|-----------------|---------------------|----------|---------|----------|-------|-----|------|
|                 | Тоо                 | Дүн      | Тоо     | Дүн      | Тоо   | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1                   | 21,261.3 | 1       | 21,261.3 | 0     | 0   | 100  |
| Зөвлөмж         | 1                   | 946.2    | 1       | 946.2    | 0     | 0   | 100  |
| Нийт дүн        | 2                   | 22,207.5 | 2       | 22,207.5 | 0     | 0   | 100  |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, түүний зарцуулалтыг хянах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 510.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 375.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 134.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 134.4 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 10,170.9 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Цахим баримтын ebarimt.mn системд шивэгдсэн 281,500.8 мянган төгрөгийн баримтыг мөнгөн хөрөнгийн зарлагын баримтуудтай тулгахад 250.0 мянган төгрөгийн и баримт дутуу байсныг нөхөж авсан;
- 2021 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар ажилчдын цалин тооцооллыг давтан шалгахад 87.6 мянган төгрөгийн цалин дутуу олгосон, давхар ажил эрхэлдэг ажилтанд ХХОАТ-ын 38.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлснийг залруулав.

#### **4.2 Төлбөрийн акт**

1. Ажиллагсдын цалингийн тооцооллыг давтан тооцоолж үзэхэд ээлжийн амралтаа авсан ажилтанд зэргийн нэмэгдэл тооцож 134.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Дээрх актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| №                               | Байгууллагын нэр          | Аудитын код             | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                           | Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга | Нийт алдаа зөрчил |       | Залруулга |       | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|---------------------------------|---------------------------|-------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|-------------------|-------|-----------|-------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                 |                           |                         |                                                                                                                                                                                     |                                                                                          | Тоо               | Дүн   | Тоо       | Дүн   | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар |                           |                         |                                                                                                                                                                                     |                                                                                          |                   |       |           |       |               |     |                 |     |         |     |
| 1                               | Соёлын өвийн үндэсний төв | АХГ-2022/206/НА-СТА-ТШЗ | Цалингийн тооцооллыг давтан шалгахад нийт 87.6 мянган төгрөгийн цалинг дутуу тооцож олгосон, давхар ажил эрхэлсэн ажилтанд ХХОАТ-ын 38.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна. | Дутуу олгосон цалинг нөхөн олгож, ХХОАТ-ын хөнгөлөлтийг суутгасан.                       | 2                 | 125.6 | 2         | 125.6 |               |     |                 |     |         |     |



Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

|                                                          |                           |                         |                                                                                                                                                  |                                                                                                    |   |       |   |       |   |       |   |  |  |  |
|----------------------------------------------------------|---------------------------|-------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|---|-------|---|-------|---|-------|---|--|--|--|
| 2                                                        | Соёлын өвийн үндэсний төв | АХГ-2022/206/НА-СТА-ТШЗ | Цахим баримтын ebarimt.mn системийн 281,500.84 мянган төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 250.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. | Цахим баримтын ebarimt.mn системд 250.0 мянган төгрөгийн и баримтыг нөхөн авсан.                   | 1 | 250.0 | 1 | 250.0 |   |       |   |  |  |  |
| 3                                                        | Соёлын өвийн үндэсний төв | АХГ-2022/206/НА-СТА-ТШЗ | Ээлжийн амралтаа авсан ажилтанд зэргийн нэмэгдэл тооцож 134.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон.                                               | Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх                                                                 | 1 | 134.4 |   |       | 1 | 134.4 |   |  |  |  |
| <b>ДҮН</b>                                               |                           |                         |                                                                                                                                                  |                                                                                                    | 4 | 510.0 | 3 | 375.6 | 1 | 134.4 |   |  |  |  |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал |                           |                         |                                                                                                                                                  |                                                                                                    |   |       |   |       |   |       |   |  |  |  |
| 1                                                        | Соёлын өвийн үндэсний төв | АХГ-2022/206/НА-СТА-ТШЗ | Шилэн дансны цахим мэдээллийн системд 146 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.                     | Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийг тус тус мөрдөж ажиллах; | 1 |       |   |       |   |       | 1 |  |  |  |
| <b>ДҮН</b>                                               |                           |                         |                                                                                                                                                  |                                                                                                    | 1 | 510.0 |   |       |   |       |   |  |  |  |
| <b>НИЙТ ДҮН</b>                                          |                           |                         |                                                                                                                                                  |                                                                                                    | 5 | 510.0 | 3 | 375.6 | 1 | 134.4 | 1 |  |  |  |





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 25 № 244/А0150458  
АХГ-2022/206/НА-СТА-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим мэдээллийн системд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдэл, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулан, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулан, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, нягтлан бодогч Ч.Өнөртогтох нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Гага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас: 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherag\Alban Sheardlaga\2022\0125 Auditin 2 Газар\217 Docx

0010800744

[illegible]

[illegible]

[illegible]